

Монгол хаадын ордны дуу хөгжмийн түүхэн тойм

Баяндүүрэнгийн Сүхбаатар^{1,*}

Товч агуулга: Монгол үндэстний дуу хөгжим нь монголчуудын баяр ёслол, тэмдэглэлт өдөр, шашин тахилга, найр наадам зэрэг амьдралын бүхий л хүрээнд чухал нэгэн бүрэлдэхүүн болдог билээ. Дуу хөгжмөөр дамжуулан монголчуудын амьдралын арга ухаан, хэв маягаас харж болохоос гадна монголчуудын түүхэн ул мөрийг өвөрмөц соёл уламжлал болон ойлголтоос тодруулж болох юм. Монгол хааны ордны дуу хөгжим нь олон арван үе шат дамжиж ирснийг түүхэн сурвалж бичиг, судалгааны бүтээлүүдэд үндэслэж, Их Монгол улсын үеийн байдал, Юань улсын үеийн байдал, Умард Юань улсын үеийн байдал, Манж Чин улсын уламжлал залгамжлал гэх олон талаас нь шинжлэн судлах болно.

Түлхүүр үг: Хааны ордон, дуу хөгжим, түүх

Удиртгал

Монголчуудын дуу хөгжим бол тэдний соёл урлагийн чухал бүрэлдэхүүн бөгөөд Монголын түүх соёлын салшгүй нэгэн толь юм. Тиймээс эрт үеийн дуу хөгжмийн талаар баримт бичигт тэмдэглэгдэн үлдсэн нь цөөн боловч, ихэвчлэн ардын аман зохиолын хэлбэрээр үндэстний зан үйлийн уламжлалыг даган улиран дамжсаар одоо үетэй золгожээ. Үүнд ардын уран сайханчид (дуучин, цоорчин, туульч)-ын амаар уламжлагдан ирсэн дуу хөгжим багтаж буй юм. Мөн сурвалжууд болох “Монголын нууц товчоо”, “Судрын чуулган” зэрэг түүхэн сурвалж бичигт тэмдэглэн үлдсэнээс гадна 13-р зууны үед монгол нутгаар дайрч, жуулчлан өнгөрсөн Плано Карпони, Виллиам де Рубрук, Марко Поло нарын тэмдэглэлд тухайн үеийн дуу хөгжмийн талаар тэмдэглэгдэн үлдсэн байдаг. Эдгээр сурвалжуудад дурдсанаар дайн тулалдаанд орохоос өмнө буюу их хаанаас хишигтэн цэргүүдэд буулгасан зарлиг ёсоор ёслолын үед, их хуралдаан, найр наадмын үеэр хөгжим тоглож, дуу дуулдаг байсан байна (Дай Хо И, Буян 2013: 267)

Судалгаанаас үзэхэд, анхандаа монголчууд гэр майхан, цацар майхнаас орд харш, бор орд, шар орд, алтан орд зэрэг болж, ордны дотор засаг төрийн их хэргийг шийдвэрлэж, төрийн ёслол зохион байгуулахдаа ёслолын дуу хөгжмийн ажиллагааг эрхлэн явуулж байсан нь харагддаг. Чингис хааны ордны дотор ордны ёслолын дуу хөгжмийг хамаардаг тусгай хариуцагч гэж байгаагүй боловч дуу хөгжимтэй холбоотой асуудлыг хариуцдаг тусгай тушаалтан бүхий хуурч хүн байснаас гадна хишигтэн цэргийн дотор нэг бүлэг шилдэг дууч, хөгжимчид онцгойрон гарч, монгол хааны ордны дуу хөгжмийн анхны

хэлбэрийг буй болгосон хэмээх судалгааны дүгнэлт байдаг (Чин улсын хууль дүрмийн цуглаан”, боть дөчин хоёр “Монгол хөгжмийн тайлбар).

1204 онд Чингис хаан Найман аймгийг дайлан ялсны дараа, Тататунгагаар уйгуржин монгол үсгийг зохиолгосноор монгол дуу төдийгүй урлагийн хөгжлийг нэг шат ахиулсан гэж үздэг байна. Энэ үеэс эхлэн, тухайн үеийн ардын дунд уламжлал болсон бөө мөргөлийн дуу бүжиг, ан авын дуу зэрэг дуу бүжгүүд хөгжихийн сацуу шинэ маягийн магтаал дуу, адуун дуу, найрын дуу зэрэг дуу хөгжим аажмаар дэлгэрч нийгэм, ард олны дунд чухал байр суурийг эзлэх болжээ. Мөн Чингис хаан Тангад иргэний хуучин хөгжмийг бас хэрэглэж байсан гэх сурвалж байдаг байна (Хөгжилт 1997: 528)

Монголчуудын хурим найрын зан үйлийн дуу

Монголчууд эрт цагаас хурим найрын зан үйл үйлддэг байсан ба жил бүр ёслол, өв тэгш дайллага, өдөр тутмын амьдралд ч найр наадам хийдэг байжээ. Монгол найр бол тал нутгийн нүүдэлчин соёлд нэгэн дутагдаж болшгүй зүйл юм. Монголын эртний сурвалж бичгүүдээс хаан өргөмжлөх, аймгийн холбоо байгуулах, ангийн олз хүртээх, дайн байлдаанд ялах үедээ их найр хийж, баярлан дуулж, бүжиглэдэг байсныг мэдэж болно. “МНТ”-д “Хамаг Монгол, Тайчууд Ононы хорхног зовор хурж хотлыг хаан болгов. Монголын жаргалан дэвсэн хуримлан жаргах бүлээ. Хутуг хан өргүүд хорхногийн саглагар модон орчин хаврагт хагалах, өвдөгт өлөг болтол дэвсэв” (Хөгжилт 1997) гэж тэмдэглэсэн байдаг. Монголчуудын дуу хөгжим өдөр тутмын амьдралын дайллага тахилга, хурим найр зэрэг эл зүйлийн найр наадамтай холбогдохоос гадна хожим нь улс төр, цэрэг дайн, гадаад харилцаатай холбогдох болсон юм. Монголын ноёд залгамжлагчаа тогтоох, хаан ор

¹ МУИС, Антропологи, археологийн тэнхим, докторант

* Холбоо барих зохиогч: 1164098553@qq.com

суух, ноёд ихсийн жинс дэвших зэрэг улс төрийн их хэрэг бүрд дуу хөгжим дутагдаж болдоггүй байв. Үүнээс гадна, хүндтэй зочин гийчин, гадаадын элчин сайд зочлоход дуу хөгжим тоглож цэнгүүлдэг байсан байна.

Ордны дуу хөгжим нь олон нийтийн найр хуримын талбайд сүр жавхааг хөгжөөн нэмэгдүүлэх томоохон ёслол байсан байна. Түүнчлэн, дуу хөгжмөө цаг үеийн онцлогт тааруулж, агуулгын хувьд тухайн нийгмийн доторх аж ахуй, соёл урлагийн байдлыг тусган, хэлбэрийн хувьд тухайн нийгмийн дуу хөгжмийн хамгийн дээд хэлбэр болсон Монголын хаад язгууртнуудын ордны ёслолд дуулж хөгжимддөг, өндөр чанартай, онцгой төрөл болсон юм. Ялангуяа ард олны дундах дуу хөгжмийн нөлөөг их ашигласан байдаг. Харин ордны дуу нь олон түмний нөлөө бага байж, нэгдмэл монголын үе дэх дээд давхаргынханд үйлчилдэг дуу хөгжим байжээ (Лувсанчойдон 2010)

Их Монгол улсын үеийн ордны дуу хөгжмийн агуулгыг үзвэл, голдуу залбирлын дуу, магтаал дуу, найр хурмын дуу, тахилгын дуу хийгээд тухайн нөхцөл байдлаас сэдэвлэн үүсгэсэн дуу бүжиг багтаж байдаг. Чингис хаан төр байгуулагдсан үеэс дуулал ихэд дэлгэрвэй” гэх бөгөөд “Юань улсын урьд монгол бэлэгтэй үгс ерөөж өгүүлэхийг ихэд эрхэмлэн явж байсан ажгуу. Одоо Чингис хааны үеийн дууллын үгс арвин бөгөөд аялгуу бас урт болбой (Цэрэндорж 2019) гэсэн байна. Энэ нь арван гуравдугаар зууны үед монголчууд бэлэг дэмбэрэл, ерөөл бүхий олон үгтэй урт аялгуут дуулалтай бөгөөд байсныг өгүүлж буй. Лувсанчойдон тухайн үеийн дууллын агуулга хэлбэрийг ийн тодорхойлохын хамт, тэдгээр дууллын дунд “Чингис хааны үеийн төрийн дуулал болбоос цэргийн сүр эзэн буяныг магтаж дуулсан төрийн дуулал олон” байдаг тухай дурдан, доорх дууллыг сийрүүлсэн байна.

Тус дуулалд эзэн хааны буянаар төр тогтож улс төвшин болсныг өгүүлэх ба үүнд “энх хамт жаргах” бэлэг дэмбэрэл байгаа нь сонирхолтой. Дууны агуулгаас бид чухам ардын дунд дуулдаг, эсвэл зөвхөн хааны ордонд дуулдаг аль нь болохыг тогтоох нь бэрх юм. Гэвч Чингис хааны үед тусгайлсан мэргэжлийн дуучин байсан тухай судлаач Лувсанчойдон тодорхой бичсэн байна.

“Тэр цагт Чингис хаан дарс уух бүр цэнгэлдэх дуулал дор их тааламжтай тул, хатан Зошийн төрхмийн хүн, нэр Азмэргэн дуулал эгшгийг сайтар нийлүүлж чадмуй. Тиймийн тул Чингис богд энэ Азмэргэнийг хэзээд дэргэдээ авч, их өршөөн явбай. Энэ Азмэргэн болбоос их хурц ямар ч хэргийг даруй ухаан гаргаж дуулал зохиож аялгууг эвлэж, хүмүүний сэтгэл лугаа нийцүүлж чадах тул тэр цагт Азмэргэнийг хүмүүс тогь хэмээн нэрийдвэй. Бараг эртний дуулал Азмэргэний олон болой” (Мансан 2004: 415)

Дээр дурдсанчлан, монголчууд өдөр тутмын амьдралд тайлга тахилга, хурим найр зэргийн зан үйл хийхээс гадна, хааны залгамжлагчийг тогтоох, шинээр хаан ор суух, ноёд ихсийн жинс дэвших гэх зэрэг төрийн их явдлыг зөвлөн хуралдуулахад Чингисийн алтан ураг, сайд түшмэд оролцон зөвшилдсөний дараа хааны ордны найр хуримын дуу хөгжим тоглогддог байжээ. Хааны ордны найр хуримын дуу хөгжим нь тухайн цагт монголчуудын улс төр, цэрэг дайн, гадаад харилцаа зэрэгтэй холбогдох болсон ба монголчуудын амьдралд ямархан том байр суурьтай байсныг олж харж болно.

Мөн тахилгын дуу хөгжимтэй холбоотой судалгааны талаар Өвөрмонголын судлаач Тайчууд Мансан нь “Шинээр тайлбарласан Монголын нууц товчоон”-д Ван хантай холбоотой дуу хөгжмийн тухай бичихдээ “Ван хан Найманы хайгуулын цэрэгт баригдаж алуулахад түүний эх “Ван хан бол эртний өтгөс их хан болой. Толгойг авчрагтун. Бид тахья” хэмээж “том цагаан эсгий дээр тавиад, аяга барьж сархад өргүүлж, хуур хуурдан хөгжим үүсгэн тахив (Баяр 1981, 90) гэжээ. Энд тухайн үеийн монголчуудын гашуудлын ёслолыг дурдсанаар барахгүй, бас хуур хуурдан хөгжим үүсгэж буй заншлыг дурджээ. Зохиогч Мансан бол одоо цагийн судлаач бөгөөд түүний шинээр тайлбарласан “нууц товчоон”-ы тайлбар нь хятад хэлэнд галиглан үйлдсэн уг эх “Монголын нууц товчоон”-ы агуулгатай зөрчилтэй зүйл харагдсангүй. Харин хуурын судалгааны тухай хүмүүс, хуур хөгжим бол Хүннү (хүн)-ийн үед нэгэнтээ байсан бөгөөд тэр нь, Хятадын “хорчин -胡琴”-ий “ху” нь хуурын “ху” байж, энэхүү “ху” нь хятад хэлэн дахь Умардын үндэстнийг заадаг “ху” болно хэмээн гэрчилж буй. Эдгээр баримтаар үндэс болгож хэсэг эрдэмтэд 12, 13 дугаар зууны үе болоход Найман, Хэрээд, Мэргэд, Татар, Буриад мэтийн олон монгол аймгийн дуу хөгжим нь тун сайн хөгжсөн байсан хэмээн үздэг байна. (Хөгжилт 1997: 507)

Өгэдэй, Гүсг, Мөнх хаадын үеийн Монгол хааны ордны дуу хөгжим

Чингис хаанаас хойш Их монгол улс нутаг дэвсгэрээ тэлж, үндэстэн хоорондын соёлын солилцоо өргөжсөнөөр Монгол үндэстний соёл урлагт ихээхэн нөлөөлж, соёл урлаг олон шинэ зүйлээр баяжин төгөлдөржжээ. 1227 онд Чингис хаан нас барсны дараа, түүний гуравдугаар хөвгүүн Өгэдэй хаан суурийг залгамжилжээ. Түүхэн тэмдэглэлд “Монголын ердийн заншил ёсоор, тэд малгайгаа авч, бүсээ ар мөр уруу унжуулж, (1228 – 1229) онд түүнийг хаан ширээнээ суулгав.... Үлэг ноён хундага өргөж, ордны дотор гаднах хүмүүс цөм гурвантаа сөгдөн мөргөөд ‘түүний хаан суудалд суусан явдал

улс гүрний минь хөгжүүлэн бадруулах болтугай!’ гэж залбиран даатгажээ (Чойжил 2013: 405) гэсэн бөгөөд “дараа нь ордонд орж өв тэгш найр хийсэн, ... тэр (Өгэдэй) энэ мэтээр дэвээ ханатал жарган цэнгэж ‘дуу бүжиг сонирхон, дуучин бүсгүйтэй садарлаж, сархад балган найрлав гэжээ (Цэрэндорж 2019). Хэдийгээр Өгэдэй хаан арван гурван жил төр барихдаа олон зүйлийг шинэчилж, шинэ бодлого нэвтрүүлж, улс төрийн байдлыг тогтворжуулж, ардын амьдралыг зохих хэмжээнд сайжруулж, улсынхаа хүчийг нэмжээ. Өгэдэй хаан Дундад иргэн улстай харилцах харилцааг маш чухалчлан үзэж, Дундад иргэн улсын шилдэг соёлыг хүлээн авч, олзлогдсон олон уран дархадын хүч хөлсөөр тансаг сайхан орд харшийг монгол нутагт байгуулсан байна. Ийнхүү монголчууд нүүдлийн мал аж ахуйн амьдралтай байснаа аажмаар суурьшлын амьдралд орж эхлэв. Нийслэл хот байгуулж, орд харш босгож төрийн хэрэг шийтгэх болсон боловч цэрэг дайн, ан ав хийх зэргээс болж, мөн нүүдлийн ордон, цацар майханд төрийн их хэрэг явдлуудыг эрхлэн явуулж, монголын уламжлалт зан заншлаа огт хаяж орхигдуулаагүй бөгөөд ордон дотор соёлт хөгжим явуулж найр хийж ордны дуу хөгжмийн агуулга хэлбэр улам баялаг болж монгол үндэстний дуу соёл урлаг илүү хөгжих болсон байна.

Энэ үеэс монголчууд өөрийн үндэстний уламжилж ирсэн дуу, урлаг соёлоо хадгалахын ялдамд бусад улс үндэстнээс шилдэг соёлыг идэвхтэйгээр авч ашигласнаар агуулга, хэлбэр, урлагийн хэв зэрэг нь ихээхэн хөгжжээ. Энэ үеийн монгол хааны ордны дуу хөгжим нь Чингис хааны үеийн “хуурч”-ийн дүрмээс тусгай дуу хөгжмийн дүрэмд шилжин ордны дуу хөгжмийг хариуцдаг тусгай тушаалтан бий болжээ. Түүхийн тэмдэглэлд “ая эгшиг, ордны ёслол хийгээд уран мэргэжилд нэвтэрч, аажмаар хүмүүсийн хүндэтгэлийг олсон хариуцагч болжээ” (Эрдэнэтэй, Оюундалай 1981: 74) нь тухайн үеийн ордны дуу хөгжмийн зохион байгуулалтын талаар тусгай мэргэжлийн байгууламжийн чанар бүхий хэлбэрт хөгжиж, том хэлбэрийн ордны дуу бүжиг, найр ёслол, харь улс орны дуу бүжиг, хөгжим зэргийг монгол хааны ордны дуу хөгжимд татварлан хэрэглэж, охь шилдгийг шингээж ордны дуу хөгжмийг нэмэн дэлгэрүүлжээ. “Өгэдэй хаан бас Алтан улсын цан хөгжмийг хэрэглэж байжээ (Лувсанчойдон 1988: 194) гэж “Монгол үндэстний бүрэн түүх”-д тэмдэглэсэн байна. Монголчууд дайн байлдаанд ялалт байгуулах үед Хятадаас гадна өрнө дахины нэн олон дуу хөгжим монгол хаадын хүрээлэлд орсон байна. Үүнийг дагалдан Хархорум хот нь өрнө дорнын урлаг соёлыг холбосон соёлын төв болжээ. Өгэдэй хааны үед Күнзийн тавин нэгдүгээр үеийн ач Күн Юан Цүве гэх хүн хаанд бараалхахаар ирээд “эдүгээ ёслол хөгжим сарниж бутарвай. Яанж, Нанж зэрэг газарт мөхсөн

Алтан улсын тайллагын хуучин түшмэд ба ёслолын дэвтэр, хөгжмийн зэвсэг олон буй амой. Түүнийг зарлигаар хурааж хэрэглэмүй (Лувсанчойдон 1988 194) хэмээн айлтгасанд хаан соёрхож зарлиг буулган, олон газрын түшмэдэд тушааж, хэрвээ мөхсөн Алтан улсын ёслол хөгжмийн хэргийг мэдэх хуучин хүн буй аваас, түүний гэр бүлийн хамт Дүн Пингийн газар шилжүүлэн нүүлгэж, тэд нарын хүнс хэрэгслийг өөр өөрийн замын доторх гувчуур гаалиас гаргаж олготун гэжээ. Күн Юан Цүве хааны зарлигийг дагаж Яанж хотноо хүрээд мөхсөн Алтан улсын хөгжмийн эрхлэгч Ши Же, ёслолын эрхлэгч Ва Же, хөгжимчин Зая Гаэ зэрэг ерэн хоёр хүнийг олж, дахин давшиж дуулах хөгжмийг зохиолгож, Чюй Фу хот дахь күнзийн сүмд сургаж боловсруулсан байдаг. Энэ тэмдэглэлээс харахад, тухайн үед өөрийн үндэстний дуу урлаг, онцгойлон ордны ёслолын хөгжмөөр улам баяжуулахын төлөө харь улс үндэстэнтэй байлдаж ялсны дараа түүний хөгжмийн зэмсгийг нь авч хэрэглэснээр барахгүй ёслолын хөгжим ойлгож мэддэг хүмүүсийг урьж, хөгжим зохиолгосон байна. Рашид-ад-дин “Судрын чуулган”-д тэмдэглэснээр “Чингис хаан баруун Ши улсыг мөхөөж, дуу хөгжмийг нь өөрийн ордны ёслол хөгжимд шингээн ашигласан бол Өгэдэй болон Мөнх хаан бас Хятад үндэстний дуу хөгжмийг өөрийн ордныхоо ёслол хөгжимд шингээн ашиглаж, өдөр тутам зугаа цэнгэл, дайлга тахилгын ёслолд ашиглаж байжээ” гэв.

Виллиам де Рубрук “Монголд жуулчилсан тэмдэглэл”-дээ “үүдний хажууд нэлээд хүмүүс тавьсан байдаг бөгөөд тэдний дэргэд гитар маягийн хөгжим барьсан хөгжимчин эр зогсож буй. Энэ улсад хэдийгээр гитар ба риль мэтийн хөгжим байхгүй боловч харин түүнээс ондоо янз янзын хөгжим буй гэж тэмдэглэсний тайлбарт нь “тэр үеийн монголчуудын хөгжмийн тухай ‘хамаг эртний хөгжимд лимбэ, хэнгэрэг хийгээд дөрвөн чавхдаст, таван чавхдаст, есөн чавхдаст гэх мэт янз бүрийн хөгжим бий” (Мансан 1985) тэмдэглэснээс харахад тухайн үеийн монголчууд найр хийх үед тусгайлсан хөгжимчин, бүжигчинтэй байсан ба хөгжмийн зэмсгийн төрөл зүйл олон болж, яг ордны дуу хөгжимд хэрэглэдэг хөгжмүүд мөн бололтой байна. Тоссоны “Монголын түүх”-д “монголчууд элдэв зүйлийн хөгжмийг үлээн, араас нь байлдааны дуугаа дуулж, хэнгэрэг дэлдэн байлдмуй” (Улалж 1989: 117) гэж тэмдэглэсэн бөгөөд “Маркопологийн аяллын тэмдэглэл”-ээс монголчууд дайн байлдаанд мордохдоо хэнгэрэг дэлдэж, дуу дуулан, байлдааны бүжиг бүжиглэдэг байсныг олж харж болно.

Өгэдэй хааны үеийн ордны ёслолын дуу хөгжим улам баяжиж, “дайны тухай ёслолт хөгжим”, харь зочныг угтах үеийн “угтах ёслолын дуу бүжиг”, “баяр ёслолын дуу хөгжим”, “хүндэтгэл ёслолын дуу

хөгжим” хийгээд “гашуудлын ёслолын дуу хөгжим” зэрэг тусгай дуу бүжгээс бүрджээ. 13 дугаар зууны дундуур Европоос хэсэг шашин дэлгэрүүлэгчид Монгол оронд ирж, тухайн үеийн Хархорум хотод Монголын олон хаантай уулзаж, мөн олон удаа ордны найр хуримд оролцсон, хааны ордны ёслолын дуу хөгжим бүжгийг сонирхсон байна. Виллиам де Рубрук дээрх тэмдэглэлдээ “гэрийн эзэн нь архи ууж эхэлмэгц нэгэн зарц нь өндөр дуунаар ‘хаа!’ гэж хашхирна. Тэгэхтэй зэрэг хөгжим барьсан эрэгтэй нь түүнийг хамсан тоглож, эр эм бүгд хөгжмийн аясыг дагаж алга ташин бүжиглэцгээнэ. Гэрийн эзэн нь ууж дуусахтай зэрэгцэн зарц нь урьдахтайгаа адил ‘хаа!’ гэж хашхирна. Ингэхтэй зэрэг хөгжим бүжиг нь тэр дороо зогсоно, үүний дараагаар нь бүгдээр архи ууцгаана” (Мансан 1985) тэмдэглэсэн бөгөөд “... баян ядуугийн ялгаагүй, бүгдээрээ их хааны өмнө алга ташиж дуулан бүжиглэдэг” гэж тэмдэглэжээ. Италийн жуулчин Плано Карпини тэмдэглэхдээ “хаад дарс уухдаа хүмүүс ирж хөгжим барьж дуулсан хойно сая эхэлж ууцгаана” гэсэн байна. Үүнээс гадна Тоссоны “Монгол түүх”-д “Батын элч хүргэсэн газар бүхэн цөм угтлага ёслол хүртмүй, хүмүүс энэ хотноос гарч ирэн архи дарс хүргэж, гар алганд дуулж агаад угтмүй” гэж тэмдэглэснээс тухайн үед монголчууд харь улсын элч түшмэдийг “угтлага ёслолын дуу бүжиг”-ээр угтдаг байсныг олж мэдэж болно.

Гүег хаан сууринд суух үед төрийн ёслолт хөгжим барьсан тухай “Дэлхийг байлдан дагуулагчдын түүх”-д “хаан сонгогдсон өдөр Ван гүн нар даяар цугларцгаан, малгайгаа авч, бүсээ дайлж зогсоцгоов. Есүй Гүегийн нэг гараас, урд Гүегийн нөгөө гараас хөтөлж, хаан суудалд түшин суулгаад, гар дахь хундагаа өргөцгөөв. Бараалхлын харшийн гадна дотно хүмүүс бүгд гурвантаа мөргөн золгож, түүнийг ‘Гүег хаан’ хэмээн өргөмжлөв. Дараа нь өв тэгш найр хийж, ... Барбад мэт баясан цэнгэхэд ертөнцийн күсрүсийн өмнө хоолой хангинуулан дуулахуйяа, бусад хүмүүс бишрэн таг дуугүй чагнана. Тэд нар энэ мэтээр архидан найрласаар Ван гүн нар ертөнцөд хосгүй Хааны өмнөөс ятга, лимбэний яруу эгшгийн аясыг хангинуулан цуурайтуулж, шөнө дөл найрлан наадаж хоолой хангинуулан дуулбай” (Лувсанчойдон 1988: 191) гэсэн бөгөөд “хөгжимт хуримын ширээнээ хундага хөнтрөхөөр хувь хүртээл болгож, наадмын талбайд шунан орогсод дууч авхайг шохоорхон ширтэж нүдний хэсгийг цатган, эгшиглэн дуулахыг чагнаж чихний хэнгэргээ баясгана” (Плано Карпини 2022) гэж тэмдэглэжээ. Үүнээс үзэхэд, энэ үед монголчууд ордны ёслолын дуу хөгжмийг маш хүндтэй хүмүүст л тоглодог болж, ордны ёслолт дуу хөгжмийн байр суурь маш өндөр болсон байна. Үүнийг Плано Карпини “Гүег хаан цацраас гарч ирээд Хайсангийн гадна хүрч очиход тэд нар ямагт

түүний өмнө дуу хөгжим барьдаг байлаа.... Өөр удирдагч ноёдод ийм хүндэт ёслолыг ер хийдэггүй” гэж тэмдэглэснээс харж болно.

Юань улсын үеийн Монгол хааны ордны дуу хөгжим

1260 онд Хубилай хаан Кайпин хотод Их Монгол улсын хааны суудлыг залгамжилж, 1271 онд улсын нэрээ “Их Юань улс” хэмээн өөрчилж, задарсан Монголыг дахин нэгтгэж, 1279 онд Өмнөд Сүн улсыг мөхөөж Юань улс байгуулжээ. Чингис хаан Монголыг нэгтгэж Их Монгол улсыг байгуулснаас аваад, Монголын нийгэм аажмаар эртний нүүдлийн, феодалын байгуулал руу шилжин орсон байна. Хубилай хаан суудалд суусны дараа дотор орны Хятад үндэстний феодал нийгмийн аж ахуй соёлын нөлөөн доор, монголчуудын феодал нийгэмд шилжин орох хурдац нэн түргэн болжээ (Жувэйни 2004). Хубилай хаан эрхийг төвд төвлөрүүлэх төрийн бодлого хэрэгжүүлж, дотор орны хамаарлыг чангатгаж, улс төр, аж ахуй, соёлын талаар хөгжүүлэх бодлого явуулж, ардын амьдрал зохих хэмжээнд сайжирснаар барахгүй, арилжаа худалдаа хөгжиж, монгол үндэстний соёл урлагийн хөгжлийн суурийг тавихад түлхэц өгчээ. Үүнийг дагалдан хааны ордны ёслолын дуу хөгжим шинэчлэгдэж хөгжсөн.

“Юань улсын түүх, ёслол хөгжмийн тэмдэглэл” хэмээх бүтээлд “Юань хэмээх улс говийн араас мандаж, төрийн ёслол найр хуримд өөрийн зан үйлээр голлодог” (Жувэйни 2004) гэх тэмдэглэснээс үзвэл ордны ёслолын дуу хөгжим нь Чингис хааны үеэс уламжлан ирж, Монгол үндэстний дуу хөгжмөөр гол болгож бусад үндэстний дуу хөгжмийг зохих хэмжээнд ашигласан гэдгийг олж мэдэж болно. Мөн “Юань улсын түүх, ёслол хөгжмийн тэмдэглэл”-д “Юань Шизу (Хубилай хаан 1260-1294 онд хаан суусан) ордны доторх хөгжимчид, танхимд дуулдаг яруу хөгжмөөр өвөг дээдсээ тахиулахыг шаардсан бөгөөд ордондоо дөрвөн зуун гаруй хөгжимчидтэй байжээ. Зи Юань гуравдугаар он (1266 он) болоход анх удаа дөрвөн талдаа хөгжим өлгөсөн, танхимд дуулсан, ёс журам, цэрэг зэвсгийн бүжиглэлийн яруу хөгжмүүдийг тахилгын сүмд өвөг дээдсээ тахихуй дур тэнгэрлэг язгуурт дээдэс, эш хан Есүхэй баатар (Есүхэй, Тэмүүжиний эцэг, хааны цолыг нэхэж өргөмжлөв)-аас Шанзун хүртэл найман тэнхим бий, бүр тус тусынхаа хөгжмийн хуудастай байдаг” (Жувэйни 2004) гэж тэмдэглэсэн бөгөөд “Монгол үндэстний түүх” бүтээлд “Шицзү Хубилай арын ордондоо сууж байхдаа Сүн Жө Чэн хөгжимчдийг хамаартугай гэж зарлиг буулгав. Тэр хаан суусан хойно Жоу Тонгийн тэргүүн онд Төвлөн засах яаманд найрын хөгжим үүсгэн өвөг дээдсээ тахиыхан хамт

зарлиг буулган ард иргэдийн хадгалж байсан Алтан улсын хөгжмийг хурааж, Шүй Тан Чэн нараар хөгжим хийлгэсэн байна” (Жувэйни 2004) гэж тэмдэглэснээс үзэхэд Юань улсын үеийн ордны ёслол дуу хөгжим нь улам дүрэмжиж, чанга болсон байна. Юань улсын үед ордны дуу хөгжмийг ёслолын яаманд хамааруулж, И фен Си (仪凤司) ээс Юн Хе Шү (云和署), Аан Хе Шү (安和署) зэрэг байгууламжид голдуу хөгжимчид хийгээд ая хөгжмийн хамаарал бүхий ажлыг явуулж, Чан Хе Шү (常和署)-т Гүй Гүй (исламууд, хотон үндэстэн)-ийн хөгжимчдийг хамаарч, Тэн Юе Шү (天乐署) -ээс голын баруун (баруун хязгаар)-ын дуу хөгжмийг хамаарч, Гун Юай Ку (广乐库) нь тусгай хөгжмийн зэмсэг, ёслолын дуу хөгжимд хэрэглэдэг бааз хэрэгсэл зэргийг хариуцаж байжээ. Үүнээс гадна ёслолын яаманд Тай Чан ёслолын хүрээлэн (太常礼仪院) хэмээх тусгай байгууламж зохион байгуулж ордны яруу хөгжим (雅乐) болон тахилга тайлгын ёслолыг хариуцаж байжээ.

Юань улсын үед ордны дуу хөгжмийн агуулга, хэлбэр улам мэргэжлийн болж ёслолын дуу хөгжим нэлээн боловсорсон хэлбэрийн талаар улам баялагжиж, хааны ордны дуу хөгжмийг их төлөв дайлга ёслолын дуу хөгжим болон яруу хөгжим гэх хоёр төрөлд хуваах болжээ. Жишээлбэл, эзэн төрийн найр хуримд ордны найр хуримын дуу хөгжим хэрэглэж, уул хад, гол мөрөн, рашаан булаг, дээдсийн тахилга зэрэгт яруу хөгжим хэрэглэх болсон байна. Мөн үүнээс гадна, ордны бүжигт хөгжим тоглодог байжээ. Дайлга ёслолын дуу хөгжим нь монгол үндэстний уламжлалт ордны дуу хөгжмийн онцлогтой байж, эзэн төрийн хүндэт угтлага болон зугаа цэнгэлд дуулж хөгжимддөг хааны ордны дуу хөгжим болсон. Төрийн их хурим найр хийхэд ордны ёслолын дуу хөгжим заавал оролцдог байжээ. Марко Поло “Аяллын тэмдэглэл”-дээ “Их хаан хундага өргөснөөр, тэнхим дотор янз бүрийн олон хөгжмүүдийг зэрэг хөгжимдөж эхэлнэ” гэсэн бөгөөд “уран сайхны авьяас чадвартай олон илбэч, циркчид Их хаан болон түүний бараа бологсдын өмнө гарч ирнэ. Тэгээд Их хааныг баясган тоглодог бөгөөд хуримд суусан бүхэн түүнийг сонирхож цэнгэлддэг юм”(Жувэйни 425) гэжээ. Үүнээс харахад ордны дайлга ёслолын дуу хөгжмийн байр суурь маш өндөр байсныг олж харж болно. Юань улсын үеийн ордны дайлга ёслолын дуу хөгжим багтаамжаар их, агуулгаар баялаг, илтгэх арга барил олонтой, эзэн хааны дайн байлдаанд ялалт олсон баатарлаг явдлыг магтан дуулахаар голлож, агуулга хэлбэрийн хувьд ордны том хэлбэрийн хөгжмийн анги, ордны дуу хөгжимт бүжиг зэрэгт хуваагдаж, хөгжмийн зэмсэг нь дайлга тахилгын хөгжмөөс ялгаатай байжээ.

“Юань улсын түүх, ёслолын хөгжмийн тэмдэглэл”-д тэмдэглэснээр Тан, Сүн улсын ордны дуу хөгжмийн дүрмийг үндэслэн ордны том хэлбэрийн

хөгжмийн бүлгэмийг дөрвөн анги болгон хуваажээ. Шинэ жилийн баярт “хөгжим дууны Вангийн анги” (乐音王队), хааны мэндэлсэн өдөрт “насан хутаг хөгжмийн анги” (寿星队, төр ёслолд “ёслолын хөгжмийн анги” (礼乐队, шашны ёслолд “шашин дэлгэрүүлэгч хөгжмийн анги” (说法队) хэмээн хувааж, анги болгонд арван жижиг анги байж, тоглох агуулгын хуваарь тодорхой, дуу бүжгийг уялдуулж, агуулгын талаар маш элбэг баялаг болгосон ажээ.

Яруу хөгжим

Юань улсын яруу хөгжмийг зохион бүтээж хэрэглэх явцад голдуу Чингис хааны үед Тангад улсын яруу хөгжмийг оруулан хэрэглэсэн ба Өгөдэй хаан, Мөнх хаан зэрэг хаадын зарлигаар Алтан улсын ёслол хөгжим, харийн бусад улсын ёслол хөгжмийг хураан цуглуулан Юань улсын яруу хөгжим бүрэлджээ. Агуулгын талаар элбэг баялаг, төрөл зүйл олон, урлагийн хэв шинж нь эгэл жирийн, төв хичээнгүй байдаг. “Юань улсын түүх, тэмдэглэл арав есдүгээр, ёслол хөгжим хоёр”-д “...арван нэгэн сард тахилгын сүмд тахилгын ёслол явуулж, дөрвөн тал хөгжим, танхимд дуулж бөхий яруу хөгжим, ёс журам, цэрэг зэвсгийн дуу бүжиг бүрэн дүүр байсан ажгуу” гэж тэмдэглэжээ. Ёслолын хөгжимд голдуу алтан хөөрөг, чулуун хас туурга, бишгүүр, хулсны багласан бишгүүр, шороон шавар бишгүүр зэрэг эртний хөгжмүүдийг хэрэглэж байсныг “Юань улсын түүх”-ийн жаран найм дугаар ботид “Юань улсын Улалж 2019, 52 үеийн ордны яруу хөгжмийн хөгжмийн зэмсэг гучин найм гаруй бий” гэж тэмдэглэснээс харж болно.

Ордны хөгжимт бүжиг

Юань улсын үеийн “ордны хөгжимт бүжиг” нь уламжлалт монгол үндэстний “хөнгөнүүн сүрлэг” шилдэг хөгжимт бүжгийн хэлбэрийг уламжлан хадгалж ирсэн суурин дээр, мөн олон харийн улс үндэстний шилдэг дуу бүжгийг шингээн авч, шашны өнгө аясыг агуулсан хөгжимт бүжгийг аажмаар бүрдүүлсэн байна. Монголчууд эрт дээр үеэс бэлэг дэмбэрлийг эрхэмлэдэг учраас ерөөл даатгалын үг олон байдаг. Үүний дагуу ерөөл магтаалын үгийг дуу шүлэгтээ оруулснаар барахгүй бүжгийн хэлбэрээр ч илтгэх болжээ. Юань улсын үе ийм ерөөл даатгалын агуулгатай хамтын бүжгийг ордны дотор хийдэг байжээ. Жишээлбэл, “олон ноён нь Юү Тэн Мэн хаалганд хүрмэгц мориноос буугаад явган явмуй. Гагцхүү тэргүүлсэн Сайд нь морь унаж шууд ормуй. Тэдний дор сургах хүрээлэнгийн бүжигчин охид өмнө нь орж зам удирдан ‘энэ дэлхий энх тайван’ хэмээх үсэг гаргаж эгшиг өргөн бүжиглэмүй”. Энэ бол хаан эзэн дайнд мордохдоо хөгжимт бүжигчдийг

хамт авч явж байгаа хэрэг болно. Мөн түүнчлэн “тэд арван зургаан тэнгэрийн шидтэний бүжиг бүжиглэх заншилтай ажгуу. Тухайлбаас, арван зургаан гоо охид оролцдог бөгөөд тэргүүн дор хэдэн багц гэзэг унжуулж, зааны ясан бурхны титэм зүүгээд, бие дор сацагт нөмрөг, улаан өнгийн дэгтэрт хормойвч, алтан сунжирт огцорго, үүлэн мөрөвч, агуу ханцуйт дагинасын хувцас, торгон цацагт шаахай өмсөж, хүн бүр номын хурлын хэрэгсэл атган, дотроос нэг нь хонх цохиур барин хөгжимдмүй (Улалж 2019: 52) гэж “Юань улсын түүх, Шөн Дин Үг тэмдэглэл”-д бичжээ. Тэнгэрийн шидтэний бүжиг бол Тан улсын үеийн хөгжимт бүжиг бөгөөд Юань улсын үед нийслэл Дайду хот болон дээд нийслэл Шандуд тоглогдож байв. Энэ бүжиг нь шашны тахилын үед хийгддэг байсан ч ордонд хааныг жарган цэнгүүлэх хөгжимт бүжгийн өнгө аястай болж иржээ.

Юань улсын ордны хөгжимчдийн хэрэглэж байсан зэмсэг нь өөрийн үндэстний хөгжмийн зэмсгийг уламжлан хэрэглэснээр барахгүй, харийн улс үндэстний хөгжмийн зэмсгийг ч хэрэглэж байжээ. Юань улсын үеийн ордны дуу хөгжмийн хөгжмийг төлөв гурван төрөл хувааж болно. Нэгдүгээрт, хятадын ордонд хэрэглэдэг яруу хөгжим ба ардын дунд дэлгэрсэн хөгжим. Удаах нь, харь үндэстний хөгжмийг авч өөрийн болгосон явдал. Гурав дахь нь Юань улсын үед гадаад харилцаа өргөжиж, гадаадын зарим хөгжмийг ордны хөгжмийг оруулан хэрэглэсэн зэрэг болно. Сүн Алтан улсын үлдэгдэл хөгжмийг ашигласан тухай “Юань улсын түүх” бүтээлд “хөгжмийн зэмсэг гучин найм гаруй бий” гэж тэмдэглэсэн нь бий. Хувьс хийгээд хуур мэтийн хөгжим бол эртнээс ардын дунд уламжилж байснаас ордны дотор орж ирсэн. Үүнээс гадна, хөгжмийн чуулгын хөгжим лимбэ, луут бишгүүр, гуурсан бишгүүр, жижиг хэнгэрэг, ятга, пипа, зэ бишгүүр, царгил зэрэг багтах юм. Эдгээрээс лимбэ Тангадаас ирсэн бөгөөд тангад болон хятадаар 鞞波 гэх буюу 鞞帕, монголчууд харин лимбэ гэж хэрэглэж заншжээ.

Юань улсын сүүлчийн жилүүдэд дайн дажин олширч, засаг, санхүү хямарч, ард иргэдийн татвар гувчуур нэмэгдэж, аж амьдрал нь доройтжээ. Улмаар ангийн тэмцэл хурцдаж, самуун дэгдэж, феодалын задрал явагдан дотоод гадаад дайн болов. 1368 онд Зү Юань Жангийн удирдсан тариачны бослого Юань улсын ноёрхлыг төгсгөв. Юань улсын сүүлчийн хаан Тогоонтөмөр (Юань Шөн Ди)-гээр удирдуулсан монголын ноёд язгууртан Хасбуу тамгаа аваад хатад, хөвгүүд охид, шадар түшмэдээ дагуулан нийслэл хот Дайду (Бээжин)-г хаяж Монгол орноо дутаасан байна. Тогоонтөмөр хаан Их Юань улсыг сэргээн байгуулах эрмэлзлээр цэргийн хүчийг дахин зохион байгуулж Мин улсын цэрэгтэй дайтсаар 1370 онд нас баржээ.

Умард Юань улсын үед Монголын тал нутагт

мөн л дайн дажин ихтэй байлаа. Монголчуудын хүн ам цөөрч, аж ахуй, соёлын хөгжил удаашран, ардын амьдрал их доройтсон байна. Монголчууд урт удаан хугацаанд уламжлан хадгалж үлдсэн соёл урлагийн өв болох олон арван сурвалж бичгүүд дайн дажны дунд үрэгдэж шатжээ. Монгол, Мин улс урт цагаан хэрмээр зааглан хоёр зуу гаруй жил өмнө, хойноо зэрэгцэн тогтсон байдалтай, дотооддоо монгол аймгууд задралын шатандаа оржээ. Ийнхүү Умард Юань улсын үед ордны дуу хөгжим цаг үедээ тохирсон шинжтэй болсон байна.

Умард Юань улсын үеийн Монгол хааны ордны дуу хөгжим

Умард Юань улс болоход Их Юань гүрний үеийн ордны яруу хөгжим, найр хуримын дуу хөгжим зэрэг том хэлбэрийн дуу хөгжмийг орхиж тухайн нийгмийн цаг үеийн агуулга хийгээд шарын шашны нөлөөн дор нүүдлийн соёлын онцлог болоод шашин шүтлэгийн чанар хослуулсан ордны дуу хөгжим бий болжээ. Тал нутгийн өргөн олон монголчууд уртын дуу, шашны дуу, цоорын дууг зохион дуулж, нүүдлийн соёлын хэлбэр бүхий урлагийг хадгалав. Хөгжмийн тухайд хувьс, ятга, хуур зэрэг монгол хөгжим улам төгөлдөржжээ.

Батмөнх Даян хаан (1464-1517) Мандухай Сэцэн хатны дэмжлэгтэйгээр хаан ширээг залгамжилж, алтан ургийн бус язгууртны улс төрийн эрхийг хасаад, эрхийг төвд төвлөрүүлэн монгол аймгуудыг дахин нэгтгэжээ. Даян хаан эрх барьсан гучин найман жилийн хугацаандаа монголын улс төр, аж ахуй, цэрэг дайн, ардын амьдралыг эмхлэн цэгцлэхийн хамт гадаад харилцаанд хянуур хандаж, дайн дажнаас сэрэмжлэн, Мин улстай эв найрамдалтай зэрэгцэн орших төрийн бодлогыг хэрэгжүүлсэн байна. Тухайлбал, Мин улсын Шюунцун хаанд хоёр улсын хооронд арилжаа худалдаа хийх бичиг илгээж байжээ. Үүний ачаар, Монгол орны ард иргэдийн амьдрал сайжирч, аж ахуй, арилжаа худалдаа, соёл урлаг зэрэг дахин мандаж эхэлсэн байна.

16 дугаар зууны дунд үед, Түмэдийн Алтан хаан (1507-1582) Мин улстай эвлэрэхийг оролдож, гэрээ хийн, найрамдал тогтоож, үйлдвэр худалдаа ба тариаланг хөгжүүлэхийг эрхэмлэж, Монгол орны аж ахуйг ихээр хөгжүүлснээс гадна соёлын талаар мөн нягт харилцаатай болсон юм. Алтан хаан шарын шашинд тун их сонирхолтой болохоор 1577 онд Хөх нуурт Цавчаалын сүмийг байгуулж, 1578 онд тус сүмд Төвөдийн шарын шашны тэргүүн Содномжамцтай уулзсанаар Монгол оронд Төвөдөөс уламжилсан бурхан шашин ихээр дэлгэрч, монгол орны улс төр, аж ахуй, соёл урлаг, ард иргэдийн өдөр тутмын амьдралд их нөлөө үзүүлсэн байна. Үүнийг дагалдан, энэ үеийн

монголчууд, ойр хавийн зэргэлдээх улс үндэстэнтэй харилцаагаа сайжруулж, эл үндэстнүүдийн шилдэг соёлыг шингээн авч, өөрийн үндэстнийхээ соёл урлагийг улам баяжуулжээ. Нэн ялангуяа дууны агуулга хэлбэрийн хувьд ихээхэн өөрчлөлт гарч шашны агуулгатай дуу бүжиг улам арвин болсон байна. Үүнийг дагалдан монголын уламжлалт хааны ордны дуу хөгжим ч орхигдолгүй улам хөгжин бадарчээ. Үүнийг Алтан хааны Мин улсад илгээсэн илтгэл бичгийн дагал зургаас мэдэж болно. Алтан хааны ордонд том хэмжээний хөгжмийн чуулгатай байж, зарим нь чавхдаст хөгжим барьж, зарим нь дэлддэг хөгжим барьсан байдаг. Монгол сайд, ноён хурим хийвэл хувьс хөгжимддөг гэж сурвалж бичигт тэмдэглэсэн байдаг. Жишээлбэл, Ойрдын ноён Эсэн үргэлж өөртөө хувьс хөгжимдөн дуу дуулдаг байжээ (Сайшаал 2001).

1604 онд Чингис хааны алтан ургийн хойчис болох Лигдэн (1592-1634) Цахрын хааны орыг залгамжилж, Лигдэн Баатар Хутагт хэмээн өргөмжилж гучин нэгэн жил (1604 -1634) төр барьсан. “Лигдэн Хутагт хаан Юань улсын Хасбуу тамга болон Хубилай хааны үед мянган лан шижир алтаар бүтээсэн Махгал бурхныг эзэмшиж, Чингис хааны алтан ургийн хувьд их ор суусан” (Сүн Лян 1976: 918) гэж “Монгол үндэстний бүрэн түүх” номд тэмдэглэсэн байдаг. Лигдэн Хутагт хаан эрх мэдлээ бататган Монголыг эрхшээхийн төлөө дэс дараатай олон арга хэмжээ авч, өвөг дээдсийнхээ их үйлсийг үргэлжлүүлэхийг хүсэж байлаа. Тэр бээр засаг төрөө бэхжүүлж, улс төр, цэргийн явдлын их эрхийг төвлөрүүлэн бататгахын сацуу шашин суртахууныг дэлгэрүүлэх, монгол нутгийг нэгтгэхээр чармайсан болно. Лигдэн Хутагт хаан эрхийг төвлөрүүлэхийн төлөө одоогийн Ар Хорчин хошууны Хансүм сумд байгаа Авга Хар уулын энгэрт нийслэл Очирт Цагаан хотыг байгуулж, цэргийн хүчээ чангаруулан, төрийн хэрэг явдлыг шийдвэрлэж байв. Үүнээс гадна, Лигдэн хаан Авга Хар уулын энгэрт байгуулсан Цагаан хотын ойролцоо алтан дээвэрт цагаан сүм босгож, Хубилай хааны үед Пагва лам мянган лангийн алтаар цутгасан Махгал бурхныг шүтэн тахиж, хурал ном үйлдэж, бурхны номыг монгол уруу орчуулах зэрэг ажлыг эрхлэн явуулж, Монгол оронд шашин дэлгэрүүлэхийн хамт “ганжуур”-ыг орчуулжээ.

Лигдэн Хутагт хаан улсын хаан байсан гучин нэгэн жилийн турш ордны дуу хөгжим улам хөгжсөн байна. Юань улсын үеэс уламжилж ирсэн ордны дуу хөгжмийн зан заншил ба ёслолт хөгжим, дайлга тахилгад яруу хөгжмийг, төрийн үйл ажиллагаанд дуулалт хөгжмийг хэрэглэж, засаг төрөөс тусгай хөгжмийг хариуцсан хүнийг томилж, үндэстний дөрвөн их баяр болон овоо тахих зэрэгт бүжгийн тоглолт гаргадаг байжээ. Алтан хааны үеэс Төвөдийн шарын шашин Монгол оронд ихээр уламжлан

дэлгэрснээс монгол хааны ордны дуу хөгжимд шашны тухай дуу хөгжим улам нэмэгдэж, төвөд үндэстний хөгжмийн бааз хүртэл монгол оронд орж ирснээр сүм хийдийн дуу хөгжим хөгжжээ. Ийнхүү монгол оронд бурхан шашны сүм хийдийн соёл, ардын уламжлалт соёл, уран зохиол, дуу хөгжимд тухайн цаг үеийн агуулга, хэлбэрийг тусгасан хааны ордны дуу хөгжмийн систем бүрэлдсэн байна.

Дүгнэлт

“Монголын нууц товчоон”, “Судрын чуулган” ба аяллын тэмдэглэлүүдэд монгол хаанд төрийн анхны үеийн төр засгаас ойрхон үүссэн учир явдлыг тэмдэглэн үлдээсэн явдал нь монгол түүх судалгааны түүхийн үнэнийг хайх чухал материал болно. Түүнээс нааш арван зургаадугаар зууны сүүлч, арван долоодугаар зууны эхэн үеийн монголчуудын нэгэн үе түүхээ эргэцүүлэх ба тэмдэглэх ажил өрнөж, олон бичиг материал бичиж үлдээжээ. Эдгээр нь бүр түүний зохиогчийн овор зогсолтоос үүсэж түүхийн хэрэг учрыг дурсан тэмдэглэсэн нь лавтай. Зохиогчийн овор зогсолтоос гадна, тэдгээр түүхийн хэрэг учир зохиогчийн сонголт шилэлтийг хүлээн дурсагдах “эрх” олсон нь аз завшаан байсан бол өнөөдөр бид тэрхүү ул мөрийг мөрдөн түүхийн тэр цаг үед тэрхүү хүрээ хэмжээнд юу болж өнгөрснийг хайн судалж болох нь гарцаагүй.

Дээрх судалгаанаас харахад Их Монгол хаант улс байгуулагдах үед хааны ордонд тусгай урлагийн хүмүүстэй байж дуу хөгжим тоглуулдаг байсан нь тодорхой байна. Тэр нь Өгөөдэй, Мөнх хааны үеийг дамжин Юань улсын үед нэлээд хөгжингүй болж, Умард Юань улсын үе, онцгойлон Умард Юань улсын хамгийн сүүлчийн хаан - Лигдэн Хутагт хааны үед ил тод нүүдлийн соёлын өвөрмөц онцлог бүхий хааны ордны дуу хөгжим болон хэлбэржин тогтсон байна.

Монгол хааны ордны дуу хөгжим нь анх эхлэх үедээ Монголын Их Хуралдай буюу хааны цацар майханд төрийн хурим найр, ёслол дайлга хийхэд тоглогдож, монгол хаад язгууртныг баясган цэнгүүлэх буюу хүндэт зочид, гадаад улсын элчин сайдыг хүлээн авч дайлахаас гадна, монгол цэргүүдийг дайн байлдаанд мордохоос өмнө сүр хүчийг нь бадраадаг байсан ажээ. Чингис хааны үеэс Монголын нутаг дэвсгэрээ өргөтгөж, харь гүрэн улс үндэстнийг дайлан дагуулах ба харилцаа тогтоох явцад, бусад улс үндэстний дуу хөгжим, шилдэг соёлыг идэвхтэй хүлээн авч, өөрийн ордны дуу хөгжмийг улам баяжуулсан байна. Юань гүрний үед орд харш байгуулж, монголын уламжлалт дуу хөгжмийг үргэлжлүүлэн уламжлан хэрэглэхийн сацуу мөн ч харь үндэстний дуу хөгжмийг хүлээн авч, ордны дуу хөгжим улам дүрэмжиж, чанга болсноор монгол хааны ордны дуу хөгжим болж сонгодог

утгаараа төгөлдөржсөн байна.

Умард Юань улсын үед монголчуудын улс төр аж ахуйн хөгжил Юань улстай харьцуулбал удааширсан боловч соёл урлагийн талаар мөн л дээдсийн шилдэг соёлыг уламжлан хөгжиж байсан. Үүнээс гадна, Умард Юань улсын үед гадаад харилцаа сайн байж, Төвөдийн бурхны шашин монгол оронд дэлгэрснээс монгол соёл зарим талаар өөрчлөгдөж монгол хааны ордны дуу хөгжимд шашны өнгө аяс нэмэгдэж, агуулга хэлбэр баялагжин, нэгэн шинэ дуу хөгжмийн систем бүрэлдсэн байна. Умард Юань улсын сүүл үед, нэн ялангуяа Цахарын Лигдэн Хутагт хааны үед монгол аймгууд задарч, нийгмийн байдал тогтуун бус үед ч монголчуудын уламжлан залгамжилсан шилдэг соёлыг ашиглан хадгалж, өөрийн онцлог бүхий монгол хааны ордны дуу хөгжим болон тогтворжиж, Манж Чин улсын ноёрхолд бууж өгөх хүртэл Лигдэн хааны ордонд Монгол хааны ордны дуу хөгжим тоглогдож байжээ. Лигдэн Хутагт хаан Манж Чин улстай тэмцэлдэж байх үед өвчнөөр нас барж, Цахрын монгол түмэн Манж Чинд буун өгч, Монголын ордны дуу хөгжим зэрэг урлаг соёлын биет ба биет бус өв нь Цахар түмнийг даган Манж Чингийн гарт орсон бөгөөд азаар одоо болтол уламжлагдан хадгалагдаж ирсэн байна. Энд монгол хааны ордны дуу хөгжим гэх нэрийн доор монголын түүхийн эл цаг үе дэх хааны ордонд ямар дуу хөгжим байсан тухай эрдэмтэн судлаачдын бүтээлийг хайн шинжилсэн болно.

Abstract

A historical overview of the music of the Mongolian court

Bayunduuren Suhebateer

Mongolian music is an integral aspect of all facets of Mongolian life, deeply woven into religious ceremonies, festivals, and everyday experiences. Through music, we gain a profound understanding of Mongolian culture, as it reveals not only the ways and styles of life but also the historical evolution of the Mongolian people. Music serves as a mirror to Mongolian traditions, cultural practices, and worldviews.

Historical sources and research highlight the development of Mongolian music, particularly within the context of the Mongol Khan's court. Over the centuries, Mongolian music has undergone numerous transformations, influenced by different political and cultural phases. This evolution can be explored through several key historical stages: the era of the Great Mongol Empire, the Yuan Dynasty, the Northern Yuan Empire, and the legacy of the Manchu Qing Empire.

Each period contributed unique elements to the music, which can be analyzed from various perspectives. The Mongol

Empire's music laid the foundation for later developments, while the Yuan Empire infused Chinese influences. The Northern Yuan Empire preserved many of the traditions from the Mongol Empire, and the Manchu Qing dynasty continued the musical legacy, passing down traditions that remain an essential part of Mongolian culture today.

In exploring these stages, we can better appreciate the historical richness of Mongolian music, its role in shaping the identity of the Mongolian people, and its continuing importance in modern Mongolian life.

Keywords: Royal Palace, Music, History

Ном зүй

Дай Хун И, Буян (2013). “Умард Юань улсын түүх” (Монгол түүхийн цуврал бичиг), Өвөр монголын соёлын хэвлэлийн хороо,

Хөгжилт (1997). Монгол үндэстний дуу хөгжим, БНХАУ, Ляонин үндэсний хэвлэлийн хороо.

Хишигтогтох (2007). Монгол ордны дууны судлал, Үндэсний хэвлэлийн хороо.

Мансан, Т. (2004). Монгол үндэстний бүрэн түүх, (тавдугаар дэвтэр), БНХАУ, Ляонин үндэсний хэвлэлийн хороо.

Цэрэндорж (2019). Монгол хааны ордны дуу хөгжмийн хөгжлийн улбаа, Дундад улсын монгол судлал”, 47 дүгээр боть.

Баяр (1981). Монголын нууц товчоон (дэд дэвтэр), Өвөр монголын ардын хэвлэлийн хороо.

Лувсанчойдон (1988). Монголын зан аалийн ойлбор, БНХАУ, Ляонин үндэсний хэвлэлийн хороо.

Эрдэнэтэй, Оюундалай (1981). “Монголын нууц товчоон” харьцуулан хянах дэвтэр”, Өвөр монголын ардын хэвлэлийн хороо.

Сайшаал (2001). Марко Пологийн аяллын тэмдэглэл, орчуулгагч, Өвөр монголын сурган хөгжлийн хэвлэлийн хороо.

Чойжил, Дулаан (2013). Алтан товч”, Өвөр монголын хэвлэлийн бүлэг, Өвөр монголын ардын хэвлэлийн хороо.

Улалж (1989). Монгол үндэстний дуу хөгжмийн түүх, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо.

Өвөр Монголын нийгмийн шинжлэх ухааны хүрээлэн (1995). “Монгол үндэстний нэвтэрхий түүх (дээд)”, Үндэстний хэвлэлийн хороо.

Сүн Лиян (1976). “Юань улсын түүх”, гуравдугаар боть, Бээжин, Дундын хэвлэлийн хүрээлэн

Хөгжилт (2003) “Монгол соёл судлалын цуврал бичиг, урлаг (дээд)”, дуу хөгжим, Өвөр Монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо.

Received: Oct. 12, 2024; Revised: Nov. 24, 2024; Accepted: Dec. 16, 2024

